



**УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2023 оны 08 сарын 22 өдөр

Дугаар 5/574

Улаанбаатар хот

Б.Дэлгэртүвшинд сахилгын
шийтгэл ногдуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 27 дугаар зүйлийн 27.4.3, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1, 37.1.16, 37.1.18 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1.1, 48.4 дэх хэсэг, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.7 дахь заалт, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2022 оны А/1300 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Улсын бүртгэлийн байгууллагын Хөдөлмөрийн дотоод журам"-ын 10.4, 10.7 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Баянгол дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн улсын ахлах бүртгэгч Баатармөнхийн Дэлгэртүвшин нь хууль, тогтоомжид заасан үүргээ биелүүлээгүй байх тул түүнд 2023 оны 08 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн сануулах сахилгын шийтгэл ногдуулсугай.


2.Өдөр тутмын үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийг мөрдөж, мэдлэг, Нийслэлийн Баянгол дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн улсын ахлах бүртгэгч Баатармөнхийн Дэлгэртүвшинд үүрэг болгосугай.

3. Албан хаагчдад ажлын хариуцлага, дэг журмыг чанд сахин ажиллахыг анхааруулж, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Нийслэлийн Улсын бүртгэлийн газар /Г.Анхныбаяр/, Баянгол дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс /Ө.Өлзийбаасан/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /Г.Цолмон/-т үүрэг болгосугай.

4. Энэ тушаалыг эс зөвшөөрвөл тушаалыг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор төрийн албаны төв байгууллагад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай..

ДАРГА

Д.ДЭЛГЭРСАЙХАН



- 142303963